



**АХМАДЫН ХОТХОН-1 ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

**Хөрөнгө худалдаж авах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын албан бичиг цахим шуудангаар явуулах, цахим архив үүсгэх үүднээс гурван үйлдэлтэй өнгөт принтер худалдан авах шаардлагатай болсон тул принтер худалдан авах ажлыг зохион байгуулахыг Гэрээний мэргэжилтэн /Г.Баатархүү/-д даалгасугай.

2. Худалдан авахад шаардагдах 396,000 /гурван зуун ерэн зургаан мянга/ төгрөгийг зохих зардлаас гаргахыг Нягтлан бодогч /С.Баяржаргал/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОТГОНБАТ